



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/18/НА-СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан
Утас:261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn
Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn
Ахлах аудитор Ш.Наран
Утас:323266 Цахим хаяг: naransh@audit.gov.mn
Аудитор: Т.Нямсүрэн
Утас:323266 Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА	
1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа	10
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.27 № 1155
танай _____-ны № _____-т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАВАА-ОЧИР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийн бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Өөрчлөлтгүй санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5, 27.7-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 05 дугаар тогтоол, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны А/14, А/32 дугаар захирамжийн дагуу 4 улс төрийн нам, 2 эвслийн 3 нам, нийт 7 улс төрийн намд 6,954.8 сая төгрөгийн төрийн дэмжлэгийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулж явуулахад нийт 2,417.5 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 2,384.0 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 177.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Z:\Yawsan_Bichig\2026\0424 SAG-25 Docx

1596090604

Бусад асуудлын хэсэг

Улс төрийн намын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 28 нам ирүүлсэн бөгөөд уг санхүүгийн тайланг хорооны M-election.mn цахим хуудсанд байршуулж олон нийтэд нээлттэй ил тод мэдээлжээ. Хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2025 онд төрийн санхүүжилт авсан болон сонгогдсон нийт 10 намын эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,477,804.7	4,463,083.3
34	УРЬДЧИЛГАА	-	62,545.1
35	БАРАА МАТЕРИАЛ	4,477,804.7	4,400,538.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,385,839.1	8,946,484.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,385,839.1	8,946,484.6
39200	Биет хөрөнгө	12,784,568.8	8,827,048.8
39300	Биет бус хөрөнгө	601,270.3	119,435.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	17,863,643.8	13,409,567.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	168,149.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	168,149.4
41300	Өглөг	-	168,149.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,863,643.8	13,241,418.4
51	Засгийн газрын хувь оролцоо	17,863,643.8	13,241,418.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	14,410,826.1	14,410,826.1
51200	Хуримтлагдсан үр дүн	3,452,817.7	(1,169,407.7)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	17,863,643.8	13,409,567.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	83,984,526.3	14,500,071.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,160,744.0	14,500,071.5
122	Тусламжийн орлого	-	14,276,389.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,823,782.4	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	82,927,453.2	19,122,296.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,927,453.2	19,122,296.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,805,066.5	11,734,231.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,616,609.4	3,284,464.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,921.7	398,977.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,170.0	7,110.9
2104	Хангамж, бараа материалын зардал	230,624.7	144,960.4
2107	Томилолт, зочны зардал	53,229.2	111,927.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	447,688.4	542,431.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,250,823.1	7,244,359.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,122,386.7	7,388,065.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,057,073.1	(4,622,225.3)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	368,976.7	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(368,976.7)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	688,096.4	(4,622,225.3)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,175,547.3		17,175,547.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,175,547.3		17,175,547.3
9	Тайлант үеийн үр дүн	688,096.4		688,096.4
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,863,643.8		17,863,643.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,863,643.8		17,863,643.8
19	Тайлант үеийн үр дүн	(4,622,225.3)		(4,622,225.3)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,241,418.4		13,241,418.4

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	78,865,753.5	14,276,476.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	225.0	14,276,476.4
120	Нийтлэг татварын бус орлого	225.0	86.9
122	Тусламжийн орлого	-	14,276,389.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,865,528.5	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,705,358.2	14,276,476.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,705,358.2	14,276,476.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,541,050.4	6,889,411.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,616,609.4	3,284,464.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,921.7	398,977.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,790.0	7,110.9
2104	Хангамж, бараа материалын зардал	48,259.6	40,947.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	71,000.0
2107	Томилолт, зочны зардал	53,229.2	111,927.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	451,470.3	570,605.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,164,770.2	2,404,377.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,164,307.8	7,387,065.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	160,395.3	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,072,517.3	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,072,517.3	-
2200	Дотоод эх үүсвэрээр	4,072,517.3	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(4,072,517.3)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,912,122.0)	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,912,122.0	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,808,241,000.00	13,823,301,035.94	984,939,964.06	93.35
12	Татварын бус орлого	14,808,241,000.00	13,823,301,035.94	984,939,964.06	93.35
122	Тусламжийн орлого	14,808,241,000.00	13,823,301,035.94	984,939,964.06	93.35
122005	Төсвөөс санхүүжих	14,808,241,000.00	13,823,301,035.94	984,939,964.06	93.35
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,808,241,000.00	13,823,301,035.94	984,939,964.06	93.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,808,241,000.00	13,823,301,035.94	984,939,964.06	93.35
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,542,034,500.00	6,830,276,777.94	711,757,722.06	90.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,634,654,200.00	3,284,464,330.54	350,189,869.46	90.37
210101	Үндсэн цалин	2,057,018,700.00	1,929,476,374.27	127,542,325.73	93.80
210102	Нэмэгдэл	916,547,000.00	764,624,485.09	151,922,514.91	83.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	308,781,200.00	236,288,438.87	72,492,761.13	76.52
210104	Урамшуулал	352,307,300.00	354,075,032.31	-1,767,732.31	100.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	452,642,200.00	398,977,854.32	53,664,345.68	88.14
210201	Тэтгэврийн даатгал	311,310,800.00	272,441,630.35	38,869,169.65	87.51
210202	Тэтгэмжийн даатгал	35,349,800.00	32,587,113.12	2,762,686.88	92.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,684,400.00	16,345,279.23	1,339,120.77	92.43
210204	Ажилгүйдлийн даатгал	17,657,400.00	15,853,161.98	1,804,238.02	89.78
210205	Эрүүл мэндийн даатгал	70,639,800.00	61,750,669.64	8,889,130.36	87.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,110,900.00	7,110,900.00	0.00	100.00
210304	Байрны түрээс	7,110,900.00	7,110,900.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,246,800.00	40,947,290.18	15,299,509.82	72.80
210401	Бичиг хэрэг	11,710,200.00	2,759,480.00	8,950,720.00	23.56
210402	Тээвэр, шатахуун	18,711,000.00	23,972,392.00	-5,261,392.00	128.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,104,300.00	11,858,418.18	8,245,881.82	58.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,721,300.00	2,357,000.00	3,364,300.00	41.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,000,000.00	71,000,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	71,000,000.00	71,000,000.00	0.00	100.00
2107	Томилот, зочны зардал	116,925,000.00	111,927,621.85	4,997,378.15	95.73
210701	Гадаад албан томилот	116,925,000.00	111,927,621.85	4,997,378.15	95.73
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,349,000.00	520,605,508.44	109,743,491.56	82.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	387,357,400.00	382,049,600.00	5,307,800.00	98.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	209,525,600.00	117,533,273.00	91,992,327.00	56.09

Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	32,378,800.00	20,435,635.44	11,943,164.56	63.11
210804	Тээврийн хэрэгслийн татвар	532,000.00	532,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	65,900.00	55,000.00	10,900.00	83.46
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,300.00	-	465,300.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24,000.00	-	24,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,573,106,400.00	2,395,243,272.61	177,863,127.39	93.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,561,800,400.00	2,383,937,272.61	177,863,127.39	93.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,306,000.00	11,306,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,266,206,500.00	6,993,024,258.00	273,182,242.00	96.24
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,206,250,300.00	6,989,404,258.00	216,846,042.00	96.99
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	7,171,640,600.00	6,954,807,698.00	216,832,902.00	96.98
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	34,609,700.00	34,596,560.00	13,140.00	99.96
2132	Бусд урсгал шилжүүлэг	59,956,200.00	3,620,000.00	56,336,200.00	6.04
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,336,200.00	-	56,336,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,620,000.00	3,620,000.00	-	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	
610001	Төсвийн байгууллага	2	2	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	43	47	(4)	
620001	Удирдах ажилтан	4	4	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	39	43	(4)	
65	МЭДЭЭЛЭЛ	-	-	-	
650003	(АА)	39	43	(4)	
650009	(ТҮ)	1	1	-	
650011	(УТ)	3	3	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,134,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,134,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,134,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,134,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,134,400.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Сонгуулийн ерөнхий хороо нь эрхэм зорилгоо “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад оршино”, алсын хараагаа “Сонгуулийг чөлөөт, шударга, ардчилсан зарчмаар, хуулийн дагуу зохион байгуулж явуулах, хараат бус, бие даасан, мэргэжлийн, Үндсэн хуульт ардчиллыг хамгаалагч төрийн байгууллага байна” гэж тодорхойлсон байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар хорооны “2024-2027 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г боловсруулж, баталсан байна. Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, хэрэгжилтийг 96.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлж тайлагнасан байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь үндсэн чиг үүрэг, түүнд нийцүүлэн тодорхойлсон эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн зорилтоо дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

1. Сонгууль, ард нийтийн санал асуулгыг ардчилсан сонгуулийн үндсэн зарчимд нийцүүлэн нээлттэй, шударга зохион байгуулах;
2. Сонгуулийн боловсрол олгох сургалт хөтөлбөр, арга хэмжээг өргөн хүрээнд, тогтмол зохион байгуулах, сонгуулийн эрх зүйн хөгжлийг дэмжсэн судалгаа хийж, санал гаргах;
3. Сонгуулийн автоматжуулсан системийн аюулгүй, найдвартай ажиллагааг бэхжүүлж, санал авах үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшилтэд шийдлийг нэвтрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
4. Улс төрийн намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалтын ил тод байдлыг нээлттэй мэдээлэх.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин

Сонгуулийн ерөнхий хороо нь Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Сонгуулийн ерөнхий хорооны дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж, Монгол Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарийг батлан, хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх дараах хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт;
- СЕХ-ны даргын 2025 оны А/15 дугаар “Сонгууль зохион байгуулж явуулах батлагдсан төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ыг захирамжаар шинэчлэн баталж, СЕХ-ны даргын 2025 оны А/53 дугаар захирамжаар журмын 3.8 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт;
- СЕХ-ны даргын 2025 оны А/33 дугаар “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2017 оны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг А/32 дугаар захирамжаар баталсан бөгөөд 2022 оны А/28 дугаар захирамж, 2025 оны А/16 дугаар захирамжаар тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Улс төрийн намуудад санхүүжилт олгодог болсонтой холбоотой үйл ажиллагааны онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

СХХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын зарим заалтыг дутуу бэлтгэж ирүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,454.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-
УРЬДЧИЛГАА	-	62.5	62.5
БАРАА МАТЕРИАЛ	4,477.8	4,400.5	(77.3)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,385.8	8,946.5	(4,439.3)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,863.6	13,409.5	(4,454.1)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	168.1	168.1
Засгийн газрын хувь оролцоо	17,863.6	13,241.4	(4,622.2)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,863.6	13,409.5	(4,454.1)

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Дүн	-	-	-

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.4.2 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 4,400.5 сая төгрөг болж, өмнөх оноос 77.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Хангамжийн материал			
Бичиг хэргийн материал	27.0	12.9	(14.1)
Аж ахуйн материал	4,279.0	4,230.0	(49.0)
Сэлбэг хэрэгсэл	110.1	93.6	(16.5)
Түлш, шатах тослох материал	2.5	0.0	(2.5)
Бусад хангамжийн материал	59.2	63.5	4.3
Дүн	4,477.8	4,400.5	(77.3)

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материалын дансны үлдэгдэл 77.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд сонгууль зохион байгуулах бэлтгэл ажилтай холбогдуулан урсгал зардлаас 157.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 234.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

3.4.3 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 8,946.5 сая төгрөг болж, өмнөх оноос 4,439.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Биет хөрөнгө	12,784.5	8,827.0	(3,957.5)
Авто-тээврийн хэрэгсэл	13.3	15.4	2.1
Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,661.5	8,664.3	(3,997.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	109.7	147.3	3.6
Биет бус хөрөнгө	601.3	119.4	(481.9)
Программ хангамж	601.3	119.4	(481.9)
Дүн	13,385.8	8,946.5	(4,439.3)

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,439.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 95.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 16.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 198.5 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоож, 9.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг Мэдээллийн технологийн төвийн үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.4 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс үлдэгдэл 168.2 сая төгрөг болж, өмнөх оноос өссөн байна.

Хүснэгт 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Байгууллагад төлөх өглөг	-	167.2	167.2
Хувь хүнд төлөх өглөг	-	1.0	1.0
Дүн	-	-	168.2

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд хэрэгжүүлсэн гэрээт ажлын үлдэгдэл төлбөр 167.2 сая төгрөг, ажилтанд олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эрх Сангийн яам нээж өгөөгүйтэй холбоотой өр үүссэн байна.

3.4.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 13,241.4 сая төгрөг болж 4,622.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Засгийн газрын оруулсан капитал	14,410.8	14,410.8	-
Хуримтлагдсан үр дүн	3,452.8	(1,169.4)	(4,622.2)
Өмнөх үеийн үр дүн	2,764.7	3,452.8	688.1
Тайлант үеийн үр дүн	688.1	(4,622.2)	(5,310.3)
Дүн	17,863.6	13,241.4	(4,622.2)

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,622.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буюу хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт/, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг улсын төсвөөс 32,207.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг Улсын Их хурал 16,457.5 сая төгрөгөөр бууруулан 15,750.3 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 942.1 сая төгрөгөөр тодотгон бууруулж, нийт төсвийг 14,808.2 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагч Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр 7 удаа 282.9 сая төгрөгийн зохицуулалт хийж, зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,823.3 сая төгрөг буюу 984.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 403.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 109.7 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 15.3 сая төгрөг, нөхөн сонгуулийн зардал 177.9 сая төгрөгөөр, засгийн газрын дотоод шилжүүлэг 216.8 сая төгрөгөөр, бусад урсгал зардал 56.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Нийт дутуу зарцуулалтын 41.0 хувь нь цалин хөлсний зардал байгаа нь тус байгууллагын цалингийн зардлын төсвийг үндэслэлтэй батлаагүйг харуулж байна. Иймд

ажиллах хүчний чиг үүргийн шинжилгээ хийж, анх баталсан орон тоо үндэслэлтэй эсэхийг тогтоож, төсвийг үнэн зөв батлуулах шаардлагатай байна.

Хүснэгт 7. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	70403	Бүх шатны сонгууль зохион байгуулах	14,808.2	13,823.3	984.9	93.3
1.1	80101	Үндсэн үйл ажиллагаа	4,592.9	4,064.3	528.6	88.5
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	49.8	49.8	-	100.0
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	337.6	332.3	5.3	98.4
1.4	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	34.6	34.6	-	100.0
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	59.9	3.6	56.3	6.0
1.6	81504	УИХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг	6,859.2	6,642.4	216.8	96.8
1.7	81555	Нөхөн болон дахин сонгууль	2,561.8	2,383.9	177.9	93.1
1.8	81568	УИХ-д суудалгүй намуудад олгох дэмжлэг	312.5	312.4	0.1	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: Монгол улсын 2025 оны төсвийн тодотголоор СЕХ-ны даргын 2025 оны батлагдсан цалингийн санг 3,634.7 сая төгрөг, орон тоог 4-р бууруулж, 43 орон тоотой байхаар баталсан боловч гүйцэтгэлээр 3,284.4 сая төгрөгийг зарцуулж, 47 орон тоогоор ажилласан байна. СЕХ-ны тамгын газрын хэлтсийн дарга 3, референт 2, мөн Мэдээллийн технологийн төвийн захирал 1, хэлтсийн дарга 2 нийт 8 орон тоонд холбогдох албан хаагчийг томилолгүй 6 сараас дээш хугацаанд түр орлон гүйцэтгэгчээр хавсран ажиллуулж байгаа нь тус байгууллагын орон тоонд чиг үүргийн шинжилгээ хийж, бүтэц орон тоог дахин оновчтой батлах шаардлага байгааг харуулж байна. УИХ-ын 2023 оны 82 дугаар тогтоолоор СЕХ-ны Тамгын газрын орон тоог 60 албан хаагч бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2024 оны Б/01 дугаар захирамжаар Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн баталж, СЕХ-ны даргын 2023 оны 17 дугаар тогтоолоор хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн бүтэц орон тоог 14 албан хаагчтай байхаар тус тус тогтоосон байна. СЕХ-ны бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулах арга хэмжээг хэрэгжээгүй байна.

Унаа, хоолны хөнгөлөлт: Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар ажлын нэг өдрийн унааны хөнгөлөлт 500 төгрөг, хоолны хөнгөлөлтийг 25000 төгрөгөөр тогтоосон байна. СЕХ-ны 2025 оны хоол, унааны хөнгөлөлтийн батлагдсан төсөв 308.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 236.3 сая төгрөг зарцуулсан байна.

Шүүхийн шийдвэрээр төрд үчруулсан хохирол: Тайлант онд шүүхийн шийдвэрээр төрд учруулсан хохирол байхгүй байна.

Гадаад албан томилолт: Гадаад албан томилолтын зардал 116.9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэл 111.9 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- Беларусь Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах хөтөлбөр -1 хүн;
- Филиппиний Улсын сонгууль ажиглагчийн хөтөлбөр-2 хүн;
- Швед улсад болсон Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн бага хуралд оролцох, санамж бичиг байгуулах-2 хүн;

- Киргизийн Сонгуулийн төв хорооноос зохион байгуулсан “Сонгуулийн оролцоонд хандах орчин үеийн хандлага, онолоос практик руу” Иссык-Кулийн чуулга уулзалт-2 хүн;
- Испани улсад болсон Нээлттэй засаглал түншлэл олон улсын байгууллагын дээд хэмжээний уулзалт -3 хүн;
- Индонез улсад зохион байгуулагдсан “Сонгуулийн үр нөлөө, тогтвортой байдал” олон улсын семинар-2 хүн;
- Киргиз Улсын Сонгууль ард нийтийн санал асуулгын хорооноос зохион байгуулсан тус улсын парламентын сонгуулийг ажиглах хөтөлбөр, цахим санал хураалт судлах-1 хүн тус тус гадаад томилолтоор ажиллажээ.

Программ хангамжийн бүртгэл: СЕХ нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн санхүүгийн программ Acolous нь 1.9 сая төгрөг, Пластик нэгтгэлийн программ 0.6 сая төгрөг, Доминион Вөүтинг Системс компанийн Сонгуулийн системийн /2 төрөл/ 2,542.7 сая төгрөг, Зурган файл хуулдаг программ 27.6 сая төгрөг, “И Энд Си” ХХК-ийн Дохиоллын системийн программ 5.7 сая төгрөг, "Интерактив" ХХК-ийн e-election.mn цахим мэдээллийн сангийн программ 264.8 сая төгрөг, “ПроGRID системс” ХХК-ийн Төхөөрөмжийн лиценз 13.5 сая төгрөг, SQL баазын лиценз 21.9 сая төгрөг, VS программын лиценз 6.5 сая төгрөг, “Бодь электроникс” ХХК-ийн e-election.mn цахим мэдээллийн санд ашиглагдаж буй виртуал серверийн лиценз 43.9 сая төгрөг, “Вертексмон” ХХК-ийн Checkpoint 4200 Firewall лиценз 5.5 сая төгрөг, Checkpoint 6200 firewall лиценз 36.9 сая төгрөг, “Сортлайк Азия” ХХК-ийн Rad studio программ хангамжийн лиценз 42.3 сая төгрөг, “Флекс солюшн групп” ХХК-ийн DevExpress программ хангамжийн лиценз 18.5 сая төгрөг, нийт 3,037.5 сая төгрөгийн программуудыг тус тус ашиглаж байна.

3.5.3 Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд 2 арга хэмжээнд 311.4 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 188.5 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харьцуулалтын аргаар хамгийн сайн үнэлэгдсэн 1 компаниас 71.0 сая төгрөгийн суурин компьютер, зөөврийн компьютер, принтер худалдан авч, үндсэн хөрөнгөд бүртгэсэн. Мөн Улс төрийн намуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг шалгаж, баталгаажуулан дүгнэлт, тайлан гаргуулахаар нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж “Миндүг аудит” ХХК сонгон 8 багцад 117,533.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, аудитыг хийсэн байна.

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Сонгуулийн ерөнхий хорооны тайлант онд хэрэгжүүлэх бүх шатны сонгууль зохион байгуулах 4 хөтөлбөрийн хүрээнд түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталж, гүйцэтгэлээр 94.3 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

СЕХ	Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
70403 Бүх шатны сонгууль зохион байгуулах				
15.1	15.1.1 Сонгох, сонгогдох эрхийг хангаж сонгогчийн оролцоог нэмэгдүүлнэ.	4	8	1.Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр "Сонгуулийн боловсрол" сэтгүүлийг улирал тутам гаргаж , хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод зориулан санал тэмдэглэх брайль хавтас зааврын хамт хэвлэж хэсгийн хороодод хүргүүлж, MGL радиогийн "Нэг дусал" нэвтрүүлгээр 10 багц мэдээллийг 1621 удаагийн давтамжтай сонгогчдод хүргэж, ТВ, сонин, сайтуудад 22 мэдээ, ярилцлага, тодруулга, нийгмийн сүлжээнд 26 пост, 7 рийл бэлтгэж түгээн тус тус хэрэгжүүлсэн 4 арга хэмжээ байна.

					2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль болсон 18 аймгийн төв болон 53 суманд Сонгогчийн өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан, сонгуулийн хууль тогтоомж, санал хэрхэн тэмдэглэх тухай, сонгогчийн боловсролын хөтөлбөрийг танилцуулж, хариуцлагатай сонгогч сургалтыг 17 аймагт зохион байгуулж нийт 510 хүүхэд залуучуудыг хамруулсан, хаврын Номын баярт оролцож сонгогч, иргэдэд мэдээ мэдээллийг хүргэсэн, Үндэсний номын сантай хамтарч их, дээд сургуулиудын оюутан залууст зориулан 14 хоног тутамд сонгуулийн боловсролын сургалтыг 9 сараас хойш тогтмол зохион байгуулж, 4 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Нийт 8 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.
15.1.2	Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд оролцогчдын чадавхыг сайжруулна.	18	19	Байнгын бус үйл ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах төрийн албан хаагчдад зориулсан "Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан" сургалт, "Сонгуулийн зохион байгуулалт" сургалтыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулиар 18 аймгийн 53 суманд, мэдээллийн технологийн багийн гишүүн болон даамлын сургалтыг 18 аймагт, нийт 71 сургалтыг зохион байгуулж, нийт 1146 төрийн албан хаагч хамрагдсан байна.	
15.1.3	Улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгоно.	7	28	Улс төрийн намын тухай хуулийн дагуу улс төрийн 37 намаас 28 нам 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ирүүлснийг хөндлөнгийн аудит хийж баталгаажуулсан. Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5, 27.7-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 05 дугаар тогтоол, СЕХ-ны даргын 2025 оны А/14, А/32 дугаар захирамжийн дагуу 4 нам, 2 эвсэл, нийт 7 намд 6.9 тэрбум төгрөгийн Төрийн дэмжлэгийг олгосон байна.	
		7	37	Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу 37 улс төрийн намын мэдээллийг e-election.mn цахим хуудсанд байршуулсан. Үүнд: улс төрийн намын үндсэн мэдээлэл, дотоод байгууллын мэдээлэл, гүйцэтгэх төв байгууллагын мэдээлэл, намын нээлттэй мэдээлэл, намын санхүүгийн мэдээ тайлангуудыг дэлгэрэнгүй байдлаар байршуулсан.	
15.1.4	Мэдээллийн сан үүсгэх, аюулгүйн болон бэлэн байдлыг хангана.	14	18	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн санал хураалтын зурган файл болон хяналтын камерын бичлэгийг аймаг, сум, хэсэг бүрээр файл үүсгэн сан болгон хадгалж байна. Мөн сонгуулийн ирц, дүн мэдээг радио, телевиз, олон нийтийн сүлжээгээр дамжуулсан.	
		3000	3000	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн санал хураалтын үйл ажиллагаанд 144 ширхэг ИСР санал авах, тоолох, дүн гаргах төхөөрөмж, 20 ширхэг старлинк төхөөрөмж ашигласан байна. Мөн хуваарийн дагуу 3000 ширхэг төхөөрөмж түүний дагалдах хэрэгсэлд техникийн үзлэг хийж нөөц батарейнуудыг хуваарийн дагуу цэнэглэж бэлэн байдлыг хангаж ажиллажээ.	

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Сонгуулийн ерөнхий хороо хооронд харилцан тохирсон гэрээний дагуу "Улс төрийн намын санхүүжилт, хандивын бүртгэл, хяналт, ил тод байдалд олон нийтийн оролцоог бэхжүүлэх" төслийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 59.1 сая төгрөгийн санхүүжилт авч, Улс төрийн намын санхүүжилт, хандивын бүртгэл, хяналт, ил тод байдлыг хангах цахим системийг хөгжүүлэх, хэрэгжүүлэгч болон хяналт тавих чиг үүрэг бүхий талуудын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Сонгуулийн ерөнхий хороо, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Улсын төрийн намын санхүүжилтийн зарцуулалтын үлдэгдлийг баталгаажуулах, тайлагнах, аудитын хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлттэй нийцүүлэн хянах процессыг тодорхой болгох, албан хаагч түр орлон гүйцэтгүүлэн хавсран гүйцэтгэж байгаа ажилтны ачаалал нэмэгдэж, ажлын чанар, үр дүн буурах, чиг үүргийн давхардал, хариуцлагын тодорхой болгох, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, СЕХ-ны бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоох, төрийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар чиг үүргийн шинжилгээ хийх, НБББББ-т нэмэлт өөрчлөлт оруулах, зарим албан тушаалын зэрэг дэвийг шинэчлэн тогтоох талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитор Т.Нямсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 3/158 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 82,927.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 829.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан ба төсвийн хэтрэлт гаргаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3,310.5 сая төгрөгийн 4 зөрчлөөс, 3,310.5 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого 27.1 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, 3 гүйлгээний дүнг 7.3 сая төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, зарлагын 157.0 сая төгрөгийн 14 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд нь мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Мэдээллийн технологийн төвийн шилэн дансанд байршуулах 171 мэдээллээс 170 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж 1 мэдээллийг оруулах хуулийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь хууль тогтоомжтой нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Тайлант онд анх удаа улс төрийн намуудад төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг улс төрийн намуудын албан хүсэлт болон холбогдох журмын батлагдсан маягтын дагуу хүсэлтийг ирүүлснээр Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газар хянаж, 3 улс төрийн намд 6,441.9 сая төгрөг, 2 эвслийн 3 улс төрийн намд 512.9 сая төгрөг, нийт 6,954.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Тус санхүүжилтээс Улс төрийн намын тухай хуульд заасан хувь, зориулалтын дагуу 3,919.5 сая төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан бөгөөд зөрүү 3,035.3 сая төгрөгийг юунд зарцуулсныг төрөөс үзүүлэх дэмжлэгийн тайланд тусгаагүй, аудитын хуулийн этгээд нь намуудын аудитлагдсан санхүүгийн тайланд төрийн санхүүжилтийн үлдэгдлийг баталгаажуулж дүгнээгүй, Сонгуулийн ерөнхий хорооны хяналт тавьж ажиллаагүй байна. Улсын төрийн намын санхүүжилтийн зарцуулалтыг аудитын дүгнэлттэй нийцүүлэн хянах, үлдэгдлийг баталгаажуулах, тайлагнах процесс тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа хуулийн хэрэгжилтийг хянахад хүндрэл учирч болзошгүй үр дагавартай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Улс төрийн намын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана", 31.2-т "Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төрийн намын санхүүжилтийн зарцуулалтын үлдэгдлийг баталгаажуулаагүй, холбогдох журмын дагуу тайлагнаагүй, аудитын хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлттэй нийцүүлэн хянах процесс тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт дутмаг байгаад зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 2: Тус хорооны нийт 5 албан хаагчаар газар хэлтсийн даргын албан үүргийг 6 сараас дээш хугацаанд түр орлон гүйцэтгүүлж 83.9 сая төгрөгийг цалингийн зардал гаргасан нь хавсран гүйцэтгэж байгаа ажилтны ачаалал нэмэгдэж, ажлын чанар, үр дүн буурах, чиг үүргийн давхардал, хариуцлагын тодорхойгүй байдал үүсэж, дотоод хяналтгүй болох эрсдэлтэй байна. Мөн СЕХ-ны бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулах арга хэмжээг хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө", 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: СЕХ-ны бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар чиг үүргийн шинжилгээ хийх, албан үүргийг 6 сараас дээш хугацаанд хавсран гүйцэтгүүлдэг зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 3: СЕХ-ны даргын 2017 оны А/32 дугаар захирамжаар баталсан "СЕХ-ны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримт бичиг"-т Сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан улс төрийн намуудад төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнах, зарцуулалтад хяналт тавьж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах талаар НБББББ-т өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан улс төрийн намуудад төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнах, зарцуулалтад хяналт тавьж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах талаар НБББББ-т өөрчлөлт оруулах зөвлөмж өгсөн.

4.4.2.1. Харьяа байгууллагын бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тус төвийн захирлын 2023 оны 10 дугаар сарын Б/30 дугаар тушаалаар программ хангамжийн инженер, ахлах референтийг албан тушаалд томилохдоо өмнөх ажлаас өөрийн хүсэлтээр гарч, тухайн албан хаагчийн өмнөх байгууллагад газрын даргаар ажиллаж байх хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 30 дугаар зарлигийн хавсралтаар тогтоосон "Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг" буюу 42.0 хувийн зэрэг дэвийн нэмэгдлийг бууруулахгүйгээр хэвээр олгосон бөгөөд албан тушаалын зэрэг дэвийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т "Зэрэг дэв олгохдоо төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшнийг харгалзана", Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.8-д "Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2-т заасны дагуу төрийн захиргааны албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тохиолдолд тухайн албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийг бууруулахгүй", 2.9-д "Төрийн захиргааны албан хаагчаас өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаал буурсан тохиолдолд тухайн төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийг бууруулахгүй", 3.1-т "Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасан төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй байгаа иргэн, мөн хуулийн 62 дугаар зүйлийн

62.1.4-т заасны дагуу төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдаж төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэн төрийн жинхэнэ албан тушаалд хууль тогтоомжийн хүрээнд томилогдвол түүний зэрэг дэвийг хэвээр хадгална" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй. Тус тогтоолын 2.3-т "Төрийн захиргааны ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Монгол Улсын сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын Агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус шийдвэрлэнэ", 2.4-т "Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг уг албан хаагчийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана" гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Тус төвийн программ хангамжийн инженер, ахлах референтийн албан тушаалын зэрэг дэвийг шинэчлэн тогтоох зөвлөмж хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Тус төвийн захирал болон 2 хэлтсийн даргын албан үүргийг 6 сараас дээш хугацаанд түр орлон гүйцэтгэж байгаа нь хавсран гүйцэтгэж байгаа нь ажилтны ачаалал нэмэгдэж, ажлын чанар, үр дүн буурах, чиг үүргийн давхардал, хариуцлагын тодорхойгүй байдал үүсэж, дотоод хяналтгүй болох эрсдэлтэй байна. Тайлант хугацаанд сул орон тоонд ажилтан авах ажлын байрны зар тавьж, шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө", 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Даргын албан үүргийг 6 сараас дээш хугацаанд түр орлон гүйцэтгүүлсэн зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 501.1 сая төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлснийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 9. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Зөвлөмж	7	501.1	7	501.1	100.0
Нийт дүн		7	501.1	7	501.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

СЕХ-ны төсвийн багцад туссан Улс төрийн намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Улс төрийн намын тухай хуулийн 39 дүгээр зүйл 39.4-т "Энэ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллага хүлээн авч хянаад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ", 39.5-д "Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана" заалтуудын дагуу аудит хийж, дүгнэлтийг хүргүүлнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн 2 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс, тус 2 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан үе шатны аудит хийсэн.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 25.5 сая төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 25.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

5.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 3.7 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тамгын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/28 дугаар тушаалаар Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын даргын мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдлийг 40.0 хувь гэж өөрчлөн тогтоож, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад тухайн жилийн төсөвтөө багтаан 2025 оны 09-12 сарын хооронд 3.7 сая төгрөгийг олгосон бөгөөд тус тушаалыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/46 дугаар тушаалаар хүчингүй болгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-т "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад тухайн жилийн төсөвтөө багтаан тушаал шийдвэр гаргасан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

5.1.2. Харьяа байгууллага

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Мэдээллийн технологийн төвийн 2025 оны санхүүгийн тайлангийн түүвэрт хамрагдах аудитаар 21.8 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 11 албан хаагчид илүү цагийн хөлс 21.8 сая төгрөгийг олгож, зардлыг зарцуулах эдийн засгийн ангилал зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2025 оны 112 тоот тушаал "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан зардлын эдийн засгийн ангилал зөрүүтэй тайлагнасан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжүүдийн хэрэгжүүлж, биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сонгуулийн ерөнхий хороо ТЕЗ	1	3.7			-	-	1	3.7		
Харьяа байгууллага	1	21.8					1	21.8		
НИЙТ	2	25.5	-	-	-	-	2	25.5	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт										
Сонгуулийн ерөнхий хороо ТЕЗ	1	191.3					1	191.3		
Дүн	1	191.3					1	191.3		
Бусад хууль тогтоомжийн хүрээнд										
Сонгуулийн ерөнхий хороо ТЕЗ	3	3,119.2					3	3,119.2		
Харьяа байгууллага	2	-					2	-		
Дүн	5	3,119.2					5	3,119.2		
НИЙТ	6	3,310.5	-	-	-	-	6	3,310.5	-	-